

Translated from Mongolian to English
“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт
"Mongolian Stock Exchange" JSC's
Annex to the Resolution №12
of the Board of Directors dated 11th March 2025.
Sealed by the stamp /Mongolian Stock Exchange/

**НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН
АРИЛЖААЛАХ ЖУРАМ
REGULATION ON RE-TRADING OF COAL
FORWARD AGREEMENT**



НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЖУРАМ
REGULATION ON RE-TRADING OF COAL FORWARD AGREEMENT

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/ ONE. GENERAL PROVISIONS.....	2
ХОЁР. ДАХИН АРИЛЖААЛАХ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН/ TWO. MINERAL COMMODITIES SUBJECT TO RE-TRADING.....	3
ГУРАВ. ХУДАЛДАХ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ/ THREE. RECEIPT, REGISTRATION, AND REJECTION OF SELL ORDERS	4
ХУДАЛДАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ/ SELL ORDER AND ITS RECEIPT	4
ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ/ FOUR. BUY ORDER AND ITS RECEIPT	7
ТАВ.АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ/ FIVE. ORGANIZATION OF TRADING	8
ЗУРГАА.ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН/ SIX. IMPLIED AGREEMENT REPORT	9
ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО/ SEVEN. SETTLEMENT	10
НАЙМ. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ/ EIGHT. ASSIGNMENT OF RIGHTS AGREEMENT	12
ЕС.АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ/ NINE. TRANSPARENCY OF TRADING INFORMATION	13
АРАВ.АРИЛЖААТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН/ TEN. DISPUTES RELATED TO TRADING	14
АРВАН НЭГ.БУСАД/ ELEVEN. MISCELLANEOUS.....	14
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын	16
Хавсралт 1	16
Annex 1 of “Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement”	18
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын	20
Хавсралт 2	20
Annex 2 of “Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement”	21
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын.....	22
Хавсралт 3	22
Annex 3 of “Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement”	22

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
 Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

Dynamic translation center
 Tel: 976-95904858
 Email: dynamictranslation123@gmail.com



Хуудас/Page 1

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт
Annex to the Resolution №12
of the Board of Directors dated 11th March 2025.

**НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН
АРИЛЖААЛАХ ЖУРАМ
REGULATION ON RE-TRADING OF COAL
FORWARD AGREEMENT**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ONE. GENERAL PROVISIONS**

- 1.1. Энэхүү журмаар "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх)-иар арилжигдсан нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах захиалгыг хүлээн авах, арилжааг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.1. This regulation governs the procedures for accepting orders to re-trade forward coal agreements traded on the "Mongolian Stock Exchange" JSC (hereinafter referred to as "Exchange"), organizing such trades, and ensuring transparency of information.
- 1.2. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, захиргааны хэм хэмжээний акт, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх) болон Биржээс баталсан бусад журам, заавраар зохицуулна.
- 1.2. Any relations not regulated by this regulation shall be governed by the Law of Mongolia on Company, the Law of Mongolia on the Securities Market, the Law of Mongolia on Mining Products Exchange, relevant legislation, resolutions of the State Great Khural (Parliament), resolutions of the Government, administrative normative act, and other regulations and instructions approved by the Financial Regulatory Commission (hereinafter referred to as "Commission") and the Exchange.
- 1.3. Энэхүү журмыг Бирж, Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.3. This regulation shall be followed by the Exchange, participants in the Exchange trading, and other participants in the Exchange market.
- 1.4. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
- 1.4. The terminology used in this regulation shall have the following meanings:
 - 1.4.1. "форвард гэрээг дахин арилжаалах" гэж нүүрсний форвард гэрээний анхны худалдан авагч нь тухайн гэрээний дагуу худалдагчаас шаардах эрхээ Бирж дээр арилжаалах замаар эрх, үүрэг шилжүүлэх үйл ажиллагааг;
 - 1.4.1. "Re-trading of forward contract" refers to the process in which the initial

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

bidder of a forward coal contract transfers the right to claim from the seller by trading such right and obligation through the Exchange;

- 1.4.2. “нийлүүлэгч” гэж Биржээр нүүрс арилжаалсан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компанийг;
- 1.4.2. “Supplier” means a mining company holding a mineral exploitation special license which sold coal through the Exchange;
- 1.4.3. “худалдагч” гэж форвард гэрээний шаардах эрхээ арилжаалах захиалга ирүүлсэн худалдан авагч хуулийн этгээдийг;
- 1.4.3. “Seller” means the legal entity that was the initial bidder under a forward contract which submits a sell order to re-trade the right to claim under the contract;
- 1.4.4. “худалдан авагч” гэж Биржид худалдан авагчаар бүртгүүлж, гэрээ байгуулсан энэ журмын 1.4.1-д заасан арилжаанд худалдан авагчаар оролцох хуулийн этгээдийг;
- 1.4.4. “Bidder” means a legal entity registered as a bidder with the Exchange and participating as a bidder in the re-trading described in Clause 1.4.1;
- 1.4.5. “хүндэтгэн үзэх шалтгаан” гэж гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, төрийн эрх бүхий байгууллагын хориг, хязгаарлалтыг ойлгох ба энэ нь тухайн улсын эрх бүхий байгууллагын гэрчилгээ, дүгнэлт, тодорхойлолтоор тогтоогдсоныг.
- 1.4.5. “Justifiable reason” means force majeure, or government bans or restrictions by an authorized government body, and must be evidenced by an official certificate, conclusion, or statement issued by the competent authority of the relevant country.

ХОЁР. ДАХИН АРИЛЖААЛАХ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН TWO. MINERAL COMMODITIES SUBJECT TO RE-TRADING

- 2.1. Дахин арилжаалах нүүрсний форвард гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1. A coal forward agreement eligible for re-trading on the exchange must meet the following requirements:
 - 2.1.1. гэрээний нийт төлбөр нь бүрэн төлөгдсөн байх (дэнчин хассан дүнгээр);
 - 2.1.1. The total agreement payment must have been fully settled (subtracting the collateral amount).
 - 2.1.2. гэрээний хугацаа дуусгавар болоогүй байх.
 - 2.1.2. The contract must not have expired.
 - 2.2. Биржээр дахин арилжаалах нүүрсний хэмжээг тонноор илэрхийлсэн байна.
 - 2.2. The quantity of coal to be re-traded on the Exchange shall be expressed in tons.
 - 2.3. Биржээр дахин арилжаалах нүүрсний форвард гэрээ нь биржээр арилжигдсан анхны арилжааны зард тусгасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлттэй ижил байна.
 - 2.3. The forward coal agreement to be re-traded must be identical in type, grade, and
- Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

quality specifications to those set forth in the original trading announcement of the initial trade which traded on the Exchange.

- 2.4. Биржээр арилжаалагдсан нүүрсний чанарын шаардлагыг нийлүүлэгч тал хариуцах бөгөөд нүүрсний чанарыг бууруулахгүй байхад шаардагдах арга хэмжээг авч ажиллана.
- 2.4. The supplier shall be responsible for ensuring the quality requirements of the coal traded on the Exchange and shall take necessary actions to prevent deterioration of the coal quality.
- 2.5. Форвард гэрээг дахин арилжаалсан тохиолдолд анх байгуулсан форвард гэрээг худалдан авагч тал үргэлжлүүлэн форвард гэрээний дагуу худалдан авагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
- 2.5. If the forward agreement is re-traded, the bidder of the original forward agreement shall continue to exercise the rights and obligations of the bidder under the forward agreement.
- 2.6. Форвард гэрээг дахин арилжаалах захиалга ирүүлсэн хэдий ч арилжаа амжилтгүй болсон форвард гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.
- 2.6. If a re-trading order for the forward agreement is submitted but the trade fails, the original forward agreement shall remain valid.

ГУРАВ. ХУДАЛДАХ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

THREE. RECEIPT, REGISTRATION, AND REJECTION OF SELL ORDERS

ХУДАЛДАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ SELL ORDER AND ITS RECEIPT

- 3.1. Худалдагч нь худалдах захиалгыг Биржийн арилжааны системд цахимаар оруулах бөгөөд захиалгын үнэн зөвийг Худалдагч өөрөө хариуцна.
- 3.1. The Seller shall enter the sell order to Exchange's trade system through online, and the Seller is responsible for the order's accuracy.
- 3.2. Худалдагч нь Биржээр арилжаалах нүүрсний захиалгыг дараах баримт бичгийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Биржийн арилжааны системд оруулна. Үүнд:
- 3.2. The seller shall enter the coal re-trading order in the Exchange's trading system no later than 7 working days before the trading session, along with the following documents:
 - 3.2.1. энэхүү журмын Хавсралт 1-т заасан "Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах захиалга";
 - 3.2.1. The "Order to Re-Trade Forward Coal Agreement" as specified in the Annex 1 of this regulation;
 - 3.2.2. хүчин төгөлдөр форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;
 - 3.2.2. A valid forward agreement and its amendments, if any;
 - 3.2.3. Биржээр арилжигдсан форвард гэрээний төлбөр төлсөн баримт;
 - 3.2.3. Proof of payment for the forward agreement traded through the Exchange;

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

- 3.2.4. нийлүүлсэн нүүрсний тоо хэмжээг баталгаажуулсан тооцоо нийлсэн акт;
- 3.2.4. Agreement Closure Act confirming the quantity of coal already supplied;
- 3.2.5. эрх шилжүүлэх гэрээ; (худалдагч тал гарын үсэг зурж, тамга дарж урьдчилан баталгаажуулсан байх)
- 3.2.5. Assignment Of Rights Agreement (must be pre-approved with signature and stamp from the seller);
- 3.2.6. бүртгэх үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- 3.2.6. Proof of payment for registration service fees.
- 3.3. Бирж нь захиалгатай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичгийг худалдагчаас гаргуулан авч болно.
- 3.3. The Exchange may require the seller to provide any additional relevant information, clarifications, or documents regarding the order.
- 3.4. Энэхүү журмын 3.2.4-т заасан тооцоо нийлсэн актад дахин арилжаалах боломжтой нүүрсний хэмжээ, нийлүүлэгч нь дахин арилжаалах нүүрсийг гэрээний хугацаанд нийлүүлж дуусах хуваарь, форвард гэрээний хугацааг түдгэлзүүлсэн огноо, форвард гэрээний худалдан авагчийн эрх, үүргийг шилжүүлэхийг зөвшөөрсөн нийлүүлэгч талын мэдэгдэл болон форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл зэрэг шаардлагатай мэдээллийг заавал тусгана.
- 3.4. The Reconciliation Act referred to in Clause 3.2.4 must contain the following mandatory information: the quantity of coal eligible for re-trading, the supply schedule for the remaining coal to be supplied within the agreement period, the date on which the forward contract was suspended, a notice from the supplier approving the transfer of the buyer's rights and obligations under the forward agreement, and consent from the supplier to publicly disclose the forward agreement and its amendments.
- 3.5. Форвард гэрээний худалдан авагчийн эрхийг шилжүүлэн авсан этгээд нь анхны худалдан авагчийн форвард гэрээний үүргийн зөрчлөөс шалтгаалж алданги, хохирол төлөх үүргийг нийлүүлэгчийн өмнө хүлээхгүй.
- 3.5. The party who acquires the bidder's rights under the forward agreement shall not be liable to the supplier for any penalties or damages arising from breaches committed by the original bidder under the forward agreement.
- 3.6. Бирж нь худалдагчийн захиалгыг бүртгэсний дараа болон арилжаа зохион байгуулагдсаны дараа нийлүүлэгч талд захиалгад тусгасан тоо хэмжээний нийлүүлэлтийг түр зогсоох, үргэлжлүүлэх мэдэгдлийг тухай бүр хүргүүлнэ.
- 3.6. After the seller's order has been registered and once the trading has been conducted, the Exchange shall promptly notify the supplier to suspend or resume supply of the quantity of coal stated in the order.
- 3.7. Худалдах захиалга нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэж, арилжааны системд оруулах ба арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө энэ журмын 3.2-т заасан баримт бичгүүдийг бүрэн оруулсан тохиолдолд арилжааны зарыг эрх шилжүүлэх гэрээний төсөл, форвард гэрээний хамт

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement



Биржийн цахим хуудсанд нийтэлнэ.

- 3.7. If the sell order meets the requirements stipulated in this regulation, it shall be registered by the order of the Executive director of the Exchange and entered into the trading system. Provided that the documents specified in Clause 3.2 of this regulation have been fully submitted no less than 5 working days prior to the trading session, the trading announcement, together with the draft of Assignment of Rights Agreement and the forward agreement, shall be published on the Exchange's official website.
- 3.8. Дараах тохиолдолд Бирж худалдах захиалгыг бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 3.8. The Exchange shall reject a sell order registration under the following circumstances:
- 3.8.1. энэхүү журмын 2.2-т заасан шаардлага хангаагүй;
- 3.8.1. The order fails to meet the requirements stated in Clause 2.2 of this regulation;
- 3.8.2. захиалгын мэдээлэл болон бүрдүүлбэр дутуу;
- 3.8.2. The order information or accompanying documents are incomplete;
- 3.8.3. энэхүү журмын 3.11-т заасныг зөрчсөн;
- 3.8.3. The provisions of Clause 3.11 of this regulation have been violated;
- 3.8.4. Биржээс шаардсан захиалгатай холбоотой нэмэлт мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй.
- 3.8.4. Failure to provide additional required information or documents within the designated timeframe.
- 3.9. Бирж нь энэхүү журмын 3.8-т заасан үндэслэлээр худалдах захиалгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай худалдагчид нэн даруй мэдэгдэнэ.
- 3.9. If the Exchange rejects the sell order registration based on the grounds specified in Clause 3.8 of this Regulation, it shall immediately notify the seller thereof.
- 3.10. Форвард гэрээг дахин арилжаалахад худалдан авагч үнийн санал ирүүлээгүй болон бусад шалтгаанаар арилжаа амжилтгүй болсон бол худалдагч нь тус арилжааны захиалгыг ажлын 2 өдрийн дотор дахин нэг удаа биржид бүртгүүлж болно.
- 3.10. If a forward agreement fails to be re-traded due to the absence of bid submissions or other reasons, the seller may re-submit the same trading order to the Exchange one more time within 2 working days.
- 3.11. Энэхүү журмын 3.10-д заасан шалтгаанаар хоёрдох удаагаа арилжаа амжилтгүй болсон тохиолдолд тухайн гэрээг дахин арилжаалах захиалгыг Бирж бүртгэхгүй. Энэ тохиолдолд Форвард гэрээний анхны худалдан авагч болон нийлүүлэгчид тухайн форвард гэрээг нэн даруй үргэлжлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Бирж мэдэгдэнэ.
- 3.11. If the second attempt at trading fails as stated in Clause 3.10, the Exchange shall not register further re-trading orders for that agreement. In such a case, the Exchange shall notify the original bidder and supplier of the forward agreement to take immediate action to resume performance of the agreement.
- 3.12. Форвард гэрээний худалдан авагчийн эрхийг шилжүүлэн авсан этгээд нь

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement



тухайн гэрээг дахин Бирж дээр арилжаалахгүй.

- 3.12. The entity that has acquired the bidder's rights under the forward agreement shall not re-trade the same agreement on the Exchange.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ FOUR. BUY ORDER AND ITS RECEIPT

- 4.1. Биржид бүртгэлтэй худалдан авагч нь өөрөө эсхүл Биржийн гишүүн брокероор дамжуулан арилжаанд оролцож болно.
- 4.1. A registered bidder at the Exchange may participate in the trading either directly or through a member broker of the Exchange.
- 4.2. Худалдан авагч, брокер нь худалдан авах захиалга өгөх, арилжаанд оролцохдоо дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.2. The bidder and broker shall undertake the following obligations when placing a bid order and participating in trading. These include:
- 4.2.1. Биржээс олгосон арилжааны системд хандах эрхээр нэвтэрч арилжаанд оролцох;
- 4.2.1. Accessing the trading system using the credentials provided by the Exchange;
- 4.2.2. өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг хангаж арилжаанд оролцох;
- 4.2.2. Ensuring readiness of their own equipment and software to participate in trading;
- 4.2.3. арилжааны системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулах, шилжүүлэх нууцлалыг алдагдуулахгүй байх, арилжааны системд нэвтрэх эрхгүй этгээд нэвтэрсэн, зохих зөвшөөрөлгүйгээр арилжааны системд үйлдэл хийснээс үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 4.2.3. Keeping access credentials confidential, not transferring them to others, and taking full responsibility for any damages resulting from unauthorized access or actions in the trading system;
- 4.2.4. арилжааны заавар, зөвлөмж, анхааруулга, албан ёсны зартай сайтар танилцсан байх;
- 4.2.4. Thoroughly reviewing trading instructions, recommendations, warnings, and official announcements;
- 4.2.5. арилжаатай холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Биржийн дүрэм, журамтай танилцсан байх;
- 4.2.5. Being familiar with the relevant laws of Mongolia, as well as rules and regulations of the Exchange related to trading;
- 4.2.6. арилжааны системтэй холбоотой ямар нэг доголдол илэрвэл Биржид яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.
- 4.2.6. Promptly notifying the Exchange in case of any malfunctions related to the trading system and taking necessary action.
- 4.3. Худалдан авагч, түүний брокер нь арилжааны системд оруулах захиалгын үнэн зөв, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

- 4.3. The bidder and their broker shall bear full responsibility for the accuracy of the orders entered into the trading system and any consequences arising therefrom.
- 4.4. Брокер нь өөрийн системийн доголдлоос үүссэн хохирлыг худалдан авагчийн өмнө үл маргах журмаар хариуцна.
- 4.4. The broker shall be liable to the bidder, without dispute, for any damages caused by malfunctions of the broker's own system.

ТАВ.АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

FIVE. ORGANIZATION OF TRADING

- 5.1. Бирж арилжааг ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.
- 5.1. The Exchange shall organize trading on working days between 10:00 AM and 5:00 PM.
- 5.2. Бирж нь захиалгыг худалдагчаас ирүүлсэн доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэйгээр арилжина.
- 5.2. The Exchange shall conduct open electronic bidding starting from the minimum price submitted by the seller.
- 5.3. Арилжааны дуудах доод үнийн хамгийн бага өөрчлөлтийн хэмжээ худалдагчийн ирүүлсэн захиалгад өөрөөр тогтоогоогүй тохиолдолд тонн тутамд 0.3 ам.доллар эсхүл 3 юаньтай дүйцэхүйц байна.
- 5.3. Unless otherwise specified in the seller's order, the minimum price increment during the bidding shall be equivalent to 0.3 USD per ton or of 3 CNY per ton.
- 5.4. Бирж нь худалдахаар зарласан нэг захиалгыг нэг худалдан авагчид худалдана.
- 5.4. Each sell order announced by the Exchange shall be sold to a single bidder.
- 5.5. Арилжаа нь дараах 3 үе шаттайгаар явагдана:
- 5.5. The trading process shall proceed in the following three stages:
- 5.5.1. захиалга бүртгэх үе;
- 5.5.1. Order registration stage;
- 5.5.2. дуудах үе;
- 5.5.2. Bidding stage;
- 5.5.3. хэлцэл хийгдэх үе.
- 5.5.3. Implied agreement conclusion stage.
- 5.6. Худалдан авах захиалга бүртгэх үе нь 60 минутын хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед худалдан авах захиалгыг өөрчлөх эсхүл цуцалж болно.
- 5.6. The order registration period for buy orders shall last for 60 minutes, during which the bidder may modify or cancel the order.
- 5.7. Захиалга бүртгэх болон дуудах үед Биржийн арилжааны систем худалдан авах захиалгыг үнээр эрэмбэлэх бөгөөд ижил үнэтэй захиалгуудын хувьд цаг хугацааны дарааллаар эрэмбэлнэ.
- 5.7. During the registration and bidding stages, the Exchange's trading system shall rank buy orders based on price, and among orders with the same price, based on the time of submission.
- 5.8. Худалдан авагч нь захиалга бүртгэх үед захиалгаа цуцалсан болон оруулаагүй бол дуудах үед захиалга оруулах боломжгүй.
- 5.8. If the bidder cancels or fails to submit an order during the registration stage, they
- Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
- Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

- will not be able to place an order during the bidding stage.
- 5.9. Худалдан авах захиалга бүртгэх үе дууссаны дараа дуудах үе нь 1 минут үргэлжлэх бөгөөд энэ үед үнийг бууруулах, захиалгыг цуцлах боломжгүй.
- 5.9. After the end of the order registration stage, the bidding stage shall last for 1 minute, during which the price cannot be lowered nor can orders be canceled.
- 5.10. Дуудах үед хамгийн дээд үнэ шинэчлэгдэх тохиолдол бүрд дуудах үе дахин 1 минутын хугацаагаар сунгагдана.
- 5.10. Each time a higher price is submitted during the bidding stage, the bidding period shall be extended by another 1 minute.
- 5.11. Дуудах үеийн 1 минутын хугацаанд дээд үнэ шинэчлэгдээгүй тохиолдолд хамгийн дээд үнийн саналаар хэлцэл хийгдэнэ.
- 5.11. If no higher bid is made within the 1-minute bidding period, the Implied agreement will be concluded at the highest bid price.
- 5.12. Энэхүү журмын 5.11-т заасны дагуу хэлцэл хийгдсэнээр тухайн арилжаа дуусгавар болно.
- 5.12. The trade shall be considered complete once an Implied agreement is concluded in accordance with clause 5.11 of this Regulation.

ЗУРГАА.ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

SIX. IMPLIED AGREEMENT REPORT

- 6.1. Бирж нь арилжаа зохион байгуулагдаж дууссанаас хойш тухай бүр арилжааны мэдээг өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлэх бөгөөд хэлцэл амжилттай хийгдсэн тохиолдолд баталгаажсан хэлцлийн тайланг худалдагч, худалдан авагч, нийлүүлэгчид тухай бүр цахимаар хүргүүлнэ.
- 6.1. The Exchange shall publish trading information on its official website upon the conclusion of each trading session. If an Implied agreement is successfully concluded, the confirmed Implied agreement report shall be electronically delivered to the seller, the bidder, and the supplier.
- 6.2. Худалдагчид хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
- 6.2. The confirmed Implied agreement report sent to the seller shall include the following information:
- 6.2.1. Биржээр арилжигдсан форвард гэрээний дугаар;
- 6.2.1. Forward agreement number traded on the Exchange;
- 6.2.2. хэлцэл хийгдсэн үнэ, хэлцлийн дугаар;
- 6.2.2. Executed Implied agreement price and Implied agreement number;
- 6.2.3. худалдан авагчаар шалгарсан хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг;
- 6.2.3. Official name, address, telephone number, and email address of the winning bidder (legal entity);
- 6.2.4. эрх шилжүүлэх гэрээг баталгаажуулах хугацаа.
- 6.2.4. Deadline for confirming the Assignment of Rights Agreement.
- 6.3. Нийлүүлэгч талд хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
- 6.3. The confirmed Implied agreement report sent to the supplier shall include the following information:

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

- 6.3.1. Биржээр арилжигдсан форвард арилжааны гэрээний дугаар;
- 6.3.1. Forward agreement number traded on the Exchange;
- 6.3.2. хэлцлийн дугаар;
- 6.3.2. Implied agreement ID;
- 6.3.3. худалдан авагчаар шалгарсан хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг.
- 6.3.3. Official name, address, telephone number, and email address of the winning bidder (legal entity).
- 6.4. Худалдан авагч эсхүл түүний брокерт хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
- 6.4. The confirmed Implied agreement report sent to the buyer or their broker shall include the following information:
 - 6.4.1. худалдагч болон нийлүүлэгч талын албан ёсны нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг;
 - 6.4.1. Official names, addresses, contact telephone numbers, and email addresses of the seller and supplier;
 - 6.4.2. хүчин төгөлдөр форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;
 - 6.4.2. Valid forward agreement and its amendments;
 - 6.4.3. эрх шилжүүлэх гэрээг баталгаажуулах хугацаа;
 - 6.4.3. Deadline for confirming the Assignment of Rights Agreement;
 - 6.4.4. төлбөр тооцоо гүйцэтгэх хугацаа, нөхцөл;
 - 6.4.4. Payment settlement deadlines and conditions;
 - 6.4.5. арилжааны шимтгэл төлөх хугацаа зэрэг мэдээлэл.
 - 6.4.5. Deadline for paying the trading fee.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

SEVEN. SETTLEMENT

- 7.1. Гэрээний үнэ, дэнчин, арилжааны шимтгэлийг анхдагч арилжааны валютаар тодорхойлно.
- 7.1. The agreement price, collateral, and trading fee shall be denominated as the original trading currency.

Дэнчин байршуулах

Collateral Placement

- 7.2. Худалдан авагч нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө арилжааны дэнчинг Биржийн тусгайлан нээсэн дансанд байршуулсан байна.
- 7.2. The bidder must place the trading collateral into the Exchange's designated account no later than 30 minutes before the trading session begins.
- 7.3. Худалдан авагч нь дэнчинг байршуулахдаа арилжааны банкин дахь өөрийн нэрийн данснаас шилжүүлэх бөгөөд гүйлгээний утга хэсэгт компанийн оноосон нэр, Биржийн арилжааны систем дэх компанийн бүртгэлийн дугаар болон "арилжааны дэнчин" гэх утгыг тусгана.
- 7.3. The bidder shall transfer the collateral from their own account at commercial bank, specifying the company's assigned name, registration number in the Exchange's trading system, and the term "trading collateral" in the transaction details.
- 7.4. Худалдан авагчийн байршуулах биржийн дэнчингийн хэмжээ нь нүүрсний доод үнээр илэрхийлсэн худалдах захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement



- 7.4. The collateral amount to be deposited by the bidder shall be equal to 10% of the total value of the sell order based on the minimum price of coal.

Арилжааны шимтгэл, үйлчилгээний хөлс
Trading Fee and Registration Service Fee

- 7.5. Арилжаанд шалгарсан худалдан авагч нь арилжааны шимтгэл төлөх бөгөөд уг шимтгэл нь хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.05 хувьтай тэнцүү байна.
- 7.5. The successful bidder must pay a trading fee, which shall be equivalent to 0.05% of the total value of the Implied agreement.
- 7.6. Брокероор дамжуулан арилжаанд оролцсон тохиолдолд энэхүү журмын 7.5-т заасан шимтгэл 0.04 хувьтай тэнцүү байна.
- 7.6. If the buyer participated through a broker, the trading fee shall be 0.04% of the total Implied agreement value as specified in clause 7.5 of this regulation.
- 7.7. Худалдагч нь ирүүлсэн захиалгын 1 тонн тутамд 15 төгрөг түүнтэй тэнцэх гадаад валют (ам.доллар, юань)-аар бүртгэх үйлчилгээний хөлс төлнө.
- 7.7. The seller shall pay a registration service fee of 15 MNT per ton or its equivalent in foreign currency (USD or CNY) based on the submitted order.
- 7.8. Энэхүү журмын 7.7-т заасан хөлсийг гадаад валютаар төлсөн тохиолдолд тухайн өдрийн Монголбанкны ханшаар тооцон шилжүүлнэ.
- 7.8. If the fee specified in clause 7.7 is paid in foreign currency, it shall be converted using the official exchange rate of the Bank of Mongolia on the payment date.
- 7.9. Худалдан авагч нь арилжааны шимтгэлийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор төлнө.
- 7.9. The bidder shall pay the trading fee within 3 working days after receiving the invoice.
- 7.10. Бирж нь бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийг буцаан олгохгүй.
- 7.10. The Exchange will not refund the registration service fee or the trading fee.

Гэрээний төлбөр
Agreement Payment

- 7.11. Худалдан авагч нь гэрээний төлбөрийг арилжаа зохион байгуулагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд нэхэмжлэхийн дагуу 100% шилжүүлнэ.
- 7.11. The bidder shall transfer 100% of the agreement payment to the Exchange's account within 3 working days following the conclusion of the trading session, in accordance with the invoice.
- 7.12. Журмын 7.11-т заасан гэрээний төлбөрийг Бирж нь баталгаажсан эрх шилжүүлэх гэрээг үндэслэн худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 7.12. Based on the confirmed Assignment of Rights Agreement, the Exchange shall transfer the agreement payment specified in clause 7.11 of this regulation to the seller's account.

Дэнчинг буцаан шилжүүлэх
Refund of Collateral

- 7.13. Арилжаа явагдаагүй, худалдан авах санал гаргагч тухайн арилжаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа зохион байгуулагдсан өдрөөс хойш Бирж нь худалдан авах санал гаргагчийн албан ёсны (тухайн хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг болон тамга тэмдэг дарсан албан тоот) хүсэлтийн дагуу ажлын 5 өдрийн дотор

Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам
 Regulation On Re-Trading Of Coal Forward Agreement

- банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр дэнчинг буцаан олгоно.
- 7.13. If the trading session was not held, or if the bidder did not participate in the trading session, or participated but was not selected, the Exchange shall return the collateral to the bidder within 5 working days from the trading date, based on an official request (bearing the signature and seal of the authorized representative of the legal entity), after deducting bank transaction fees.
- 7.14. Бирж нь худалдан авагчаар шалгарсан этгээдийн дэнчинг Журмын 7.11-т заасны дагуу гэрээний төлбөр Биржийн дансанд байршсаны дараа худалдан авагчийн ирүүлсэн нэхэмжлэх, төлбөр төлсөн баримтыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор буцаан олгоно.
- 7.14. The Exchange shall return the collateral of the selected bidder within 5 working days after receiving the invoice and proof of payment from the bidder, following the deposit of the agreement payment into the Exchange's account in accordance with Clause 7.11 of this Regulation.
- 7.15. Энэ журмын 7.13, 7.14-т заасны дагуу дэнчинг буцаахдаа анх шилжүүлсэн дансанд, анх орж ирсэн валютаар шилжүүлнэ.
- 7.15. The collateral will be refunded to the original account from which it was received, and in the original currency in which it was transferred.
- 7.16. Энэ журмын 7.13-т заасан хүсэлт, 7.14-т заасан баримтыг ирүүлээгүй тохиолдолд дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээсэнд тооцно.
- 7.16. If the request referred to in Clause 7.13 or the documents in Clause 7.14 are not submitted, the collateral shall be considered retained in the Exchange's account for participation in the next trading session.
- 7.17. Хэлцэл амжилттай хийгдсэн боловч худалдан авагчаар шалгарсан этгээд нь гэрээний төлбөрийг хугацаандаа эсхүл бүрэн шилжүүлээгүй, эрх шилжүүлэх гэрээг ажлын 3 өдөрт багтаан баталгаажуулж, цахимаар ирүүлээгүй тохиолдолд Бирж нь дэнчинг арилжааны шимтгэл хассан дүнгээр худалдагчид шилжүүлнэ.
- 7.17. If an Implied agreement was successfully concluded but the selected bidder fails to transfer the agreement payment in full and on time, or fails to certify and submit the Assignment of Rights Agreement within 3 working days, the Exchange shall transfer the collateral to the seller after deducting the trading fee.
- 7.18. Журмын 7.17 дахь хэсэгт заасан үүргээ Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаантайгаар биелүүлээгүй тохиолдолд дээрх зохицуулалт хамаарахгүй.
- 7.18. The above provision shall not apply if the buyer fails to fulfill the obligation stated in the Clause 7.17 without a valid reason.

НАЙМ. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ **EIGHT. ASSIGNMENT OF RIGHTS AGREEMENT**

- 8.1. Эрх шилжүүлэх гэрээг худалдагч худалдан авагч нь энэхүү журмын Хавсралт 3-т заасан загвараар бичгээр байгуулна.
